



**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/166

Есөнбулаг


┌ **Үнэлгээний хороо байгуулах тухай** ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам” А/254 дүгээр тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх Есөнбулаг сумын Ентүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртэлх авто зам, Хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг, Хөгжил хорооллын доод талаас 3, 4 дүгээр гудамжинд хатуу хучилттай авто зам тавих (үргэлжлүүлэх) ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- |                           |                             |   |
|---------------------------|-----------------------------|---|
| Үнэлгээний хорооны дарга: | Г.Болдбаатар                | (Байгаль, орчин аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)                        |
| Гишүүд:                   | З.Жаргалтуяа                | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) |
|                           | Ё.Нарангарав                | (Иргэний нийгмийн төлөөлөл) (тохиролцсоноор)  |
| Нарийн бичиг:             | С.Сүхбаатар<br>Д.Нарандулам | (Есөнбулаг сумын иргэн) (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)                                    |

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай, шуурхай зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг үнэлгээний хороо (Г.Болдбаатар)-нд үүрэг болгосугай.

  
 ОРЛОГЧ Г.ЧИНБАТ

